


dekonta

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ, БҮТЭЭГДЭХҮҮН



КОМПАНИЙН ТУХАЙ

Төв болон Зүүн Европын орнуудад экологийн салбарт явуулж буй үйл ажиллагаараа шилдгээр шалгарсан “ДЕКОНТА” компаниас Та бүхэнд дараахь үйлчилгээ, бүтээгдээхүүнийг санал болгож байна. Үүнд,

Бохирдсон газрын судалгаа, нөхөн сэргээлт хийх

Аюултай хог хаягдлыг зайлуулах

Экологийн аваар ослын үр дагаврыг шуурхай арилгах

Барилга байгууламж нураах, буулгах, хог хаягдлыг зөөх, цэвэрлэх, талбайг чөлөөлөх

Байгаль орчны хамгаалалт, экологийн асуудлаар зөвлөгөө өгөх

Байгаль орчны хамгаалалт, экологийн хяналт-шинжилгээ (мониторинг), лабораторийн үйлчилгээ үзүүлэх


Аж үйлдвэрийн хаялт, цацаргалт, гаргалт, ялгаралт зэргийг зайлуулахад зориулсан багаж хэрэгсэл

Байгаль орчны судалгаа, шинжилгээ, боловсруулах ажлыг гүйцэтгэх



“ДЕКОНТА” компани тооны хэлээр: Тус компани нь

- 1992 онд Чех Улсад байгуулагдсан
- Мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага бүхий **150** орчим мэргэжилтэн тус компанид ажилладаг (**80** хувь нь их, дээд сургууль төгсөгчид, **10** хувь нь докторын зэрэгтэй болно)
- Жилийн эргэлт: **20 орчим сая ЕВРО**
- Жил бүр гадаадын **10 гаруй** улсад **400** орчим экологийн төсөл хэрэгжүүлж байна
- ISO **9001**, ISO **14001**, OHSAS **18001** зэрэг гэрчилгээ авсан болно
- Чех, Унгар, Польш, Румын, Орос, Серб, Словак зэрэг **7** улсад салбараа нээн ажиллуулж байна.



АЖИЛЛАХ ХҮЧИН, БАГАЖ ХЭРЭГСЭЛ, БАЙГУУЛАМЖ

- Хими, геологи, биологи, инженерчлэл, иргэний, цахилгааны болон байгаль орчны хамгааллын инженерчлэл, экологи, хөдөө аж ахуй, хууль зүй, эдийн засаг зэрэг олон салбарыг хамарсан мэргэжлийн багуудаас гадна гадаад улс орнуудад ажиллаж дадлага туршлагатай мэргэжилтэн, төслийн менежеруудтай болно.
- Компанийн мэдэлд байдаг багаж хэрэгсэл, байгууламжаар дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэх бүрэн боломжтой. Үүнд,
 - Бохирдсон газрыг физик, хими болон биотехнологийн аргаар нөхөн сэргээх
 - Газар дээр нь судалгаа хийх - өрөмдөх / дээж авах / газрын талбайг хэмжих, шалгах
 - Хог хаягдлыг малтаж гаргах / зөөн тээвэрлэх / зайлуулах
 - Экологийн осол аваар гарсан тохиолдолд өдөр бүр 24 цагийн турш зогсолтгүй ажиллаж үүссэн үр дагаварыг арилгах
- Семинар зохион байгуулах
- Автомашины гараж, агуулах
- Европ даяар био аргаар цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийдэг 20 байгууламж ажиллуулж байна
- Хими, микробиологи, тенологийн лаборатори
- Компанийн мэдлийн байгаль орчны эрдэм шинжилгээний төв
- Өгөгдөл цуглуулах, үнэлэх, дүрд шингээх, математикийн загвар зохион бүтээх зэрэгт зориулагдсан сүүлийн үеийн хамгийн шинэ техник, программ хангамж



БОХИРДСОН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ

“Д ЕКОНТА” компани нь гадаадын хэд хэдэн улсад ажиллахдаа органик болон органик бус янз бүрийн бодисоор бохирдсон газар талбайг олон зуугаар нь бохирдлоос амжилттай ангижруулсан. Бохирдлын шинж чанар, бохирдсон газар, талбайн онцлогт аль болох зохицсон, хамгийн тохиромжтой гэж үзсэн нөхөн сэргээлтийн аргыг ашигладаг. Бохирдлоос ангижруулдаг хоёр аргачлалыг сийрүүлбэл:



- Газар дээр нь бус нөхөн сэргээлт хийх (“Ex situ” remediation) – бохирдсон хөрсийг малтаж, бохирдсон гүний усыг нь сорж гаргаад цаашид зайлуулах арга хэмжээ авах;
- Газар дээр нь нөхөн сэргээлт хийх (“In situ” remediation) – бохирдсон хөрс малтах, гүний усыг сорж гаргалгүйгээр газар дээр нь цэвэрлэж, нөхөн сэргээх.





“ДЕКОНТА” компани нь нөхөн сэргээх ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах ноу-хау, арга туршлага, материал, багаж хэрэгсэл зэргийг эзэмшдэг болно. Үүнд,

ФИЗИКИЙН АРГА	ХИМИЙН АРГА	БИОЛОГИЙН АРГА	БУСАД
Хөрс / Хог хаягдал: бутрах, скрининг шинжилгээ, ангилан ялгалт өтгөрөлт/тогтворжуулалт хөрсний уурыг авах угаалга чандарлалт дулааны десорпци	Хөрс / Хог хаягдал: химийн исэлдэл химийн редукци саармагжуулалт	Хөрс / Хог хаягдал: биологийн нөхөн сэргээлт биологийн агааржуулалт ургамалжуулалт	Хөрс / Хог хаягдал: ландфиллийн арга шатахуун болгон хувиргах хог хаягдал булах битүүмжилсэн сав барих сууриас тусгаарлах (capping)
Гүний ус: air sparing гүний усыг сорох, доорхи аргаар цэвэрлэх: ■ гравитацийн аргаар тусгаарлах ■ агаарын урсгалаар ууршдаг бодис зайлуулах ■ шингээлт (адсорбци) ■ коагуляци ■ флокуляци ■ эсрэг осмосис	Гүний ус: химийн исэлдэл химийн редукци саармагжуулалт	Гүний ус: биологийн нөхөн сэргээлт биологийн редукцийн хлоргүйжүүлэлт биологийн редукци bio-slurping	Гүний ус: хамгаалах гидравлик хаалт урвалын хаалт хянаггдаг/эрчимжүүлсэн задрал газар доорхи тусгаарлагч хана

ГАЗАР ТАЛБАЙГ СУДЛАХ, ДЭЭЖ АВАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

“Д ЕКОНТА” компани нь дор дурдсан салбарт газар дээр нь судалгаа шинжилгээ хийх, дээж авахаас гадна байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн хяналт шинжилгээний үйл ажиллагаа явуулах арвин туршлагатай. Үүнд,

- хөрс
- хог хаягдал
- барилга байгууламж
- лаг шавар, тунадас
- гүний ус
- гадаргууны ус
- хөрсний хий
- агаар



“ДЕКОНТА” компанийн нарийн мэргэжил эзэмшсэн ажилтнууд судалгаа шинжилгээ, дээж авалт, хяналт шинжилгээ зэрэг үйл ажиллагааг хийх бөгөөд ажил явуулахад шаардагдах лиценц зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, гэрчилгээ, өөрийн гэсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал, түүний дотор өрмийн машин, гараар ажиллуулдаг өрмийн тоног төхөөрөмж, дээж авагч, насос, хээрийн шинжилгээ, хэмжих багаж хэрэгсэл, өгөгдөл бичигч аппарат, дээж хадгалах сав, дээж хадгалах ба тээвэрлэх хөргөх сав, ашигласан дээж авалтын багажийг цэвэрлэх, ариутгах хэрэгсэл зэргээр тоноглогдсон болно.

ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АППАРАТ БА ЗӨӨВРИЙН ЛАБОРАТОРИ

Раман спектрометр

Хээрийн шинжилгээний энэхүү хосгүй аппарат нь органик, органик бус бодис, түүний нэгдлүүд, дэлбэрэгч бодис, хар тамхи зэрэг нийт 6 мянга гаруй бодисыг тогтоох чадвартай.

“ДЕЛТА” рентген флуоресценцийн гарын спектрометр (XRF Analyzer DELTA)

Бохирдсон хөрс, лаг зэрэгт агуулагдсан хортой металл, бусад бохирдуулагч аюултай бодисыг шууд илрүүлэх чадвартай нэн орчин үеийн хээрийн шинжлэгч аппарат болно.

“EcoProbe 5” аппарат

Энэхүү аппарат нь судалгааны талбайд түргэн ууршдаг органик нэгдлийг газар дээр нь илрүүлэх, шинжлэхэд зориулагдсан ашиглахад хялбар, найдвартай багаж бөгөөд хөрсний хийн нийт концентраци хэмждэг PID мэдрэгч, метан, газрын тосны нүүрстөрөгч, нүүрстөрөгчийн хоёрдагч ислийн хэмжээг тус тусд нь тогтоох чадвартай IR шинжлэгчийг хослуулсан багаж юм.



Үйлчлүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд “ДЕКОНТА” компани нь доорхи ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тусгайлан тоноглогдсон зөөврийн лаборатори ажиллуулах боломжтой.

- Задлан шинжилгээний лаборатори
- Микробиологийн лаборатори
- Дээж боловсруулах лаборатори

Зөөврийн лабораторийг түрээслүүлэх эсвэл туршлага бүхий ажлын багийн хамт нийлүүлэх боломжтой.

ӨРМИЙН АЖИЛ

“Д ЕКОНТА” компани өөрийн “AMS PowerProbe”, “JaNo” маркийн өрмийн төхөөрөмж ашигласнаар дараахь үйлчилгээ санал болгож байна.

- Цохилуурт өрөмдлөг (сонгосон гүний давхаргаас хөрсний дээж авах)
- Эргэлтэт голтой өрөмдлөг
- Хяналт шинжилгээ (monitoring)-ийн түр ба байнгын худаг барих
- Газар дээр нь химийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хэрэгжүүлэхэд зориулан инъекцийн худаг барих
- Нэвтрэхийн шалгалт
- Хайгуулын өрөмдлөг
- Дулааны насосын зориулалттай өрөмдлөг
- Анкер, микро шон



АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Агаар бохирдуулж буй бодисийн хэмжээг тодорхойлох, агаарын чанарт хяналт шинжилгээ хийх магадлан итгэмжлэгдсэн үйлчилгээг “ДЕКОНТА” компани санал болгож байна. Тус компанийн нарийн мэргэжлийн туршлагатай ажилтнуудаас бүрдсэн агаарын чанарын шинжилгээний баг нь нэн шинэ үеийн техник, тоног төхөөрөмжийн туслалцаатай гадаадад дотоодын үйлчлүүлэгчдийнхээ хүсэлтэд нийцсэн чанарын дээд зэргийн баталгаа бүхий үйлчилгээ үзүүлдэг юм.

“Деконта” компани нь үйл ажиллагааныхаа хүрээнд дараахь үйлчилгээг үзүүлж байна. Үүнд,

- Агаарын бохирдолтын суурин эх үүсвэрийн эрх бүхий хяналт шинжилгээ
- Агаарт агуулагдсан бохирдуулагч бодисийн техникийн хэмжилгээ
- Хүрээлэн буй орчны агаарын чанарын техникийн хэмжилгээ
- Хөрсний хийн чанарын хээрийн хэмжилгээ



БАЙГАЛЬ ОРЧИНД УЧИРСАН АВААР ОСЛЫН УРШГИЙГ АРИЛГАХ ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ



Осол аваар болон өөр бусад замаар хортой, аюултай химийн бодис, байгаль орчинд ялгарснаас үүссэн уршгийг арилгах иж бүрэн шуурхай үйлчилгээг тус компани үзүүлдэг юм. Иж бүрэн үйлчилгээнд ялгарч асгарсан химийн бодисийн тархалтыг таслан зогсоох анхны арга хэмжээнээс эхлэн тухайн газарт хийгдэх эцсийн нөхөн сэргээлт хүртэлхи ажлууд багтана.

Аваар ослоос үүссэн уршгийг арилгах шуурхай үйлчилгээг өдөр бүр 24 цагийн турш Чех Улсын нийт нутгийг хамруулан үзүүлдэг бөгөөд дуудлагыг +420 602 686 622 дугаартай утсаар өгнө. Дуудлага өгснөөс хойш 30 минутын дотор шуурхай үйлчилгээний баг гарахад бэлэн болсон байна.





“ДЕКОНТА” компани нь Чех Улсын Түргэн Тусламжийн Нэгдсэн Системийн бүрэлдэхүүнд багтахгаас гадна тус улсын Гал түймэртэй тэмцэх албаны удирдах төвөөр дамжуулан Дотоод хэргийн яамтай хамтран ажилладаг болно.

Багаж, тоног төхөөрөмж

- Түргэн тусламжийн машин (land rover)
- Түргэн тусламжийн моторт завь
- Экскаватор
- Ачааны машин
- Аюултай бодис тээвэрлэх ачааны машин
- Аюултай болон дэлбэрдэг бодис сорох насос
- Хор хөнөөлтэй бодистой ажиллахад зориулагдсан хамгаалалтын хэрэгсэл
- Бохирдлоос арилгах багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмж
- Химийн бодис илрүүлэгч багаж
- Аюултай бодисуудын цахим мэдээллийн сан

Уг үйлчилгээ нь Тээвэр, мэдээллийн ослын “ТРИНС” систем болон Нийслэл Прага хотын онцгой байдал, аюулаас хамгаалах системд багтдаг.



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ

Аюултай хог хаягдал зайлуулах, хянах салбарт “ДЕКОНТА” компани иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тус компани нь хорт аюултай хог хаягдлыг био технологийн аргаар зайлуулан устгах салбарт Чех Улс төдийгүй хог хаягдлыг биологийн аргаар устгах 20 гаруй байгууламж ажиллуулж байгаа Төв болон Зүүн Европын орнуудын хэмжээнд тэргүүн эгнээнд явж байгаа болно.

Тус компаниас аюултай хог хаягдал устган зайлуулах салбарт үзүүлж буй үйлчилгээнд дараахь ажлууд орно. Үүнд,

- Хог хаягдлыг боловсруулж шатахуун болгон хувиргах
- Аж үйлдвэрийн хог хаягдлыг дахин боловсруулах
- Лаг ба тоосны өтгөрөлт/тогтворжуулалт
- Хог хаягдлыг физикийн аргаар бохирдлоос ангижруулах (агааржуулах, угаах гэх мэт)
- Хог хаягдлыг химийн аргаар бохирдлоос ангижруулах (химийн исэлдэл)
- Хог хаягдлыг дулааны аргаар боловсруулах, устгах
- Хог хаягдлыг ландфиллийн аргаар булах
- Хог хаягдал булсан газрыг нөхөн сэргээх



“ДЕКОНТА” компани хог хаягдлыг анхан цэгээс хогийн цэг хүртэл тээвэрлэх, ачиж буулгах, жигнэх, хог хаягдал устгах, зайлуулах, хог хаягдлаас ялгарч буй аюултай бодисийн хорт чанарын шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг холбогдох бүх үйл ажиллагаа явуулдгаас гадна хог хаягдал хийх зориулалтын сав нийлүүлдэг болно.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ НУРААХ, БУУЛГАХ, АШИГЛАЛТЫГ ЗОГСООХ, ТЕХНОЛОГИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ

“ДЕКОНТА” компани үйл ажиллагааныхаа хүрээнд барилга байгууламж нураах, буулгах, ашиглалтыг зогсоох зэрэг олон тооны төсөл хэрэгжүүлсэн бөгөөд төслийн жинхэнэ гүйцэтгэлээс гадна барилга байгууламжийн судалгаа, дээж авалт, шинжилгээ хийх, барилга байгууламж нураах, буулгах, задлах загвар боловсруулах, барилга байгууламжийн нураах ажлыг үе шатчилан хуваах түүнчлэн бусад зорилгоор / дахин ашиглах талаар судалгаа хийх, хог хаягдлыг зөөх, талбай цэвэрлэж чөлөөлөх зардлын үнэлгээ гаргах зэрэг ажлыг хийдэг болно.

Тус компани шөрмөсөн чулуунаас үүссэн бохирдолтой холбогдох дараахь үйлчилгээ үзүүлдэг:

- Шөрмөсөн чулууны судалгаа шинжилгээ
- Шөрмөсөн чулууг арилгах
- Шөрмөсөн чулууны хаягдлыг зайлуулах
- Шөрмөсөн чулууны хаягдлыг зайлуулах ажлыг загварчлан, зөвшөөрөл өгөх

“ДЕКОНТА” компани нь газрын тос боловсруулах үйлдвэр, тос шатахуун хадгалах сав бүхий газар, цахилгаан станц, химийн үйлдвэр болон үйлдвэрлэлийн бусад салбарт мэргэжсэн технологийн цэвэрлэгээг мэргэжлийн түвшинд хийх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд үүнд дараахь төрлийн үйлчилгээ хамрагдана.

- Тос шатахуун хадгалах сав цэвэрлэх
- Дамжуулах болон ус зайлуулах хоолой систем цэвэрлэх
- Технологийн унтраах тоног төхөөрөмжийг цэвэрлэх
- Нөөцлүүр / өтөг угаадасны / сав цэвэрлэх



ЛАБОРАТОРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХӨГЖҮҮЛЭН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Д ЕКОНТА” компани нь аналитик, микробиологийн болон технологийн лабораторийн төрөл бүрийн шинжилгээ, тест зэргийн үйлчилгээ үзүүлдэг. Үүнд дараахь шинжилгээний төрөл зүйл орно.

- Хөрс, хог хаягдал, лаг, тунадас, барилгын материал, ус, хаягдал ус, агаар ба хийн дээжийн химийн (органик, органик бус) шинжилгээ
- Иж бүрдэл микробиологийн шинжилгээ
- Байгаль орчинд нөлөөлөх хорт чанарыг тогтоох

Тус компанийн Усти над Лабем, Држетовице, Острава зэрэг хотод оршдог аналитик ба микробиологийн лабораториуд нь нэн орчин үеийн шинжлэгч, хэмжигч багажаар тоноглогдсноос гадна ISO/IEC 17 025 стандартын шаардлагыг хангадаг бөгөөд холбогдох хууль тогтоомж, техникийн норм стандарт, аргачлалын зааварт нийцсэн үйл ажиллагаа явуулдаг юм.

Бохирдсон хог хаягдал, бохирдсон талбайг биологийн аргаар нөхөн сэргээх ажиллагааны биологийн бэлтгэлийг тус компанийн Држетовице болон Острава хотын биотехнологийн лабораторид боловсруулдаг.

Држетовице болон Сланы хотын технологийн лабораторид хог хаягдал зайлуулах, нөхөн сэргээлтийн шинэ арга, технологийг боловсруулж туршдаг.


“ДЕКОНТА” компани нь эрдэм шинжилгээний болон байгаль орчны шинэ технологи боловсруулахад ажилд жилдээ 1 сая гаруй ЕВРО зарцуулж байна. Үүнээс гадна Чех болон Европын олон төслүүд дээр хамтран ажиллах явцдаа байгаль орчныг хамгаалах салбарт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж буй Европын тэргүүлэгч их сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй ажлын ойр дотно харилцаа тогтоосон юм.



ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

“Д ЕКОНТА” компани нь дараахь асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Үүнд,

- Байгаль орчинд холбогдох бүх талын (due dilligence) болон нийцлийн аудит
- Байгаль орчинд холбогдох аудит (түүнчлэн Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Дэлхийн банкны протокол, зааврын дагуу гүйцэтгэх аудит)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (EIA), судалгаанд экспертиз хийх
- Чанарын менежмент (ISO 9001), байгаль орчныг хамгаалах менежмент (ISO 14001), эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент (OHSAS 18001)-ийн тогтолцоо нэвтрүүлэхэд зориулсан зөвлөх үйлчилгээ
- Үндэсний хууль тогтоомжийн дагуу бохирдлыг бууруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх шаардлагыг хамарсан зөвшөөрөл



- Дуу чимээний түвшин хэмжилт, судалгаа
- Агаарын бохирдлын судалгаа
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Экспертиз
- Байгаль орчинд болон хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх байдлын судалгаа
- Байгаль орчин хамгаалалтай холбоотой үйлчилгээний аутсорсинг
- Байгаль орчинд холбогдох төслийн хяналт (хараат бус гуравдагч этгээдээр хийгдэх шалгалт)

БИО ШҮҮЛТҮҮР

Био шүүлт бол үнэрийг хяналтад байлгах, агаарт агуулагдах органик бүрэлдэхүүний бохирдлыг зайлуулахад үр дүн сайтай төдийгүй эдийн засгийн хувьд нааштай шийдэл болно.

Био шүүлтүүрийг эм, хими, хуванцарын үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл, будаг, гадар будгийн үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг устгаж боловсруулах үйлдвэр, био хийн станц, хүнсний үйлдвэрлэл зэрэг салбарт ашиглахад тохиромжтой.

“ДЕКОНТА” компани нь дараахь био шүүлтүүрийг санал болгож байна. Үүнд,

- Био шүүлтүүрийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр нийлүүлэх
- Био шүүлтүүрийг зохион бүтээх
- Био шүүлтийн үр ашгийг тодорхойлох туршилтын шалгалт хийх
- Био шүүлтүүрийг хэмжих, хянан шалгах, ажиллагааг нь тохируулах
- Био шүүлтүүрийн засвар үйлчилгээ, урсгал засвар хийх



ХОГ ХАЯГДАЛ, УС, АГААРЫН БОХИРДЛЫГ АРИЛГАХАД ЗОРИУЛСАН БАГАЖ ХЭРЭГСЭЛ

“ДЕКОНТА” компани нь хог хаягдал зайлуулахад зориулсан дараахь багаж хэрэгслүүдийг санал болгож байна. Үүнд,

- Тогтворжуулалт / өтгөрүүлэлтийн зөөврийн (чингэлэгтэй) байгууламж
- Хөрс угаах зөөврийн байгууламж
- Тоос / хагас хатуу хаягдал бутлах тоног төхөөрөмж
- Шавар шавхай хуулах, сороход зориулсан хөвөгч экскаватор

“ДЕКОНТА” компани нь агаарын бохирдлыг арилгахад зориулсан дараахь багаж хэрэгсэл санал болгож байна. Үүнд,

- Био шүүлтүүр (дээр үзнэ үү)
- Идэвхжүүлсэн карбонт шингээлтийн шүүр
- Идэвхжүүлсэн карбонт нөхөн сэргээлтийн нэгжүүд

“ДЕКОНТА” компани нь хаягдал ус цэвэршүүлэхэд зориулсан дараахь тоног төхөөрөмж санал болгож байна. Үүнд,

- Био реактор
- Чингэлэгт байгууламж (гравитацийн аргаар тусгаарлах, агаарын урсгалаар ууршдаг бодис зайлуулах, шингээлт)
- Ус цэвэршүүлэх намагшсан газрыг барих (доор үзнэ үү)



ТУСГАЙЛАН БАРИГДСАН НАМАГШСАН ГАЗАР

Тусгай зориулалтын намагшсан газар (Constructed wetlands) бол тосгон, жижиг хот суурин газар, үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэхэд эдийн засгийн хувьд нааштай бөгөөд технологийн хувьд үр ашигтай шийдэл болно.

Хаягдал усыг тухайн газрын онцлогт тохируулж тусгайлан барьсан намагшсан газарт оруулж, намагшсан газарт ургадаг тусгай ургамлын үндсээр дамжуулан урсаж буй уснаас ялгаруулдаг цэвэрлэх бодисоор цэвэрлэдэг.

“ДЕКОНТА” компани дараахь зүйлийг санал болгож байна. Үүнд,

- Тусгай зориулалтын намагшсан газрыг түлхүүр гаргуулах нөхцөлтэйгээр нийлүүлэх
- Намагшсан газрыг барихад тохиромжтой газар талбайг сонгох
- Намагшсан газрын зураг төсөл боловсруулах, зөвшөөрөл олгуулах
- Намагшсан газарт ургуулахад тохиромжтой ургамлыг сонгох, нийлүүлэх, ургуулах
- Намагшсан газрыг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх



ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД

“Д ЕКОНТА” компани байгаль орчны хамгаалах салбарт жил бүр хэдэн зуун захиалга авч, төсөл хэргжүүлдэг бөгөөд манай үйлчлүүлэгчдийн тоонд тэргүүний томоохон үйлдвэр, барилгын компани, олон улсын байгууллага, банк, яам, дүүрэг, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд орно.

Зарим үйлчлүүлэгчдийн нэрс:

- Хими, нефть болон газрын тос боловсруулах үйлдвэр: Unipetrol, Slovnaft, MOL, PKN Orlen, Orlen Lietuva, Hexion, Akzo Nobel, Benzina, Istrochem
- Эрчим хүч: E.ON, Өмнө Чехийн газны үйлдвэр, Баруун Чехийн эрчим хүчний байгууллага, Transgas
- Металлургийн үйлдвэрлэл: US Steel, Feramo, Vítkovice Steel, Mittal Steel
- Инжинерчлэл, авто машины үйлдвэрлэл: ČKD DIZ, GDX Automotive, TRW
- Хүнс, хэрэглээний барааны үйлдвэрлэл: Крушовицегийн хаант пивны үйлдвэр, DUO, Dermacol, Tesco
- Барилга зуучлалын компани: Central Group, Red Group, CEI Building
- Тээвэрийн байгууллага: Šepro, Mero, Чехийн төмөр зам, ČSA, Прага хотын нисэх онгоцны буудал
- Барилга угсралтын компани: Skanska, Барилгын суурь тавих байгууллага, Metrostav, Eurovia
- Яам, төрийн байгууллагууд: Чех Улсын арми, Сангийн яам, Худалдаа, аж үйлдвэрийн яам, Байгаль орчны яам
- Олон улсын байгууллагууд: Дэлхийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, NATO, UNDP, UNEP



ХОЛБОО БАРИХ

Чех Улс

“ДЕКОНТА” ХК /DEKONTA, a.s.
Dřetovice (удирдах төв)
Dřetovice 109, 273 42 Stehelčevy
Утас: +420 312 292 960
Факс: +420 312 292 966
Э-шуудан: dretovice@dekonta.cz

Прага хот (оффис)

Volutová 2523, 158 00 Praha 5
Утас: +420 235 522 252-3
Факс: +420 235 522 254
Э-шуудан: info@dekonta.cz

Польш Улс

**„ДЕКОНТА – Полска” Сп. з.о.о.
/ DEKONTA - Polska Sp. z.o.o.**
Варшав (удирдах төв)
Jagiellonska 76,
Warszawa 03-301, Polska
Утас: +48 41 3621882
Факс: +48 41 3621882
Э-шуудан: biuro@dekonta.pl,
biuro@dekonta.com

Киелце хот (оффис)

Ściegiennego 252, Kielce 25-116,
Polska
Утас: +48 41 362 18 82
Э-шуудан: biuro@dekonta.pl

Серб Улс

“ДЕКОНТА” д.о.о. / DEKONTA d.o.o.
Bulevar Zorana Đinđića 87/4
11070 Belgrade, Serbia
Утас: +381 113 017 741
Факс: +381 113 111 762
Э-шуудан: office@dekonta.rs

Словак Улс

**“ДЕКОНТА Словенско” ХХК
/ DEKONTA Slovensko, spol.s r.o.**
Odeská 49, 821 06 Bratislava
Slovenská republika
Утас / Факс: + 421 245 527 672
Гар утас: +421 910 788 321
Э-шуудан: slovensko@dekonta.com

Орос Улс

**“ДЕКОНТА Геолинк” ХХК
/ ООО “DEKONTA Geolink”**
Варшавское шоссе д. 35, стр. 1
(River Plaza)
117105 Москва, Россия
Утас: +7 495 380 1680
Факс: +7 495 380 1684
Э-шуудан: mail@dekolink.ru

Румын Улс

“ДЕКОНТА” СРЛ / DEKONTA SRL
Anul 1848 street, 14
1000559 Ploiesti, Romania
Утас: +403 44100284
Факс: +403 44100284
Э-шуудан: romania@dekonta.com

Унгар Улс

**“Деконта-Өко” Кфт.
/ Dekonta-Öko Kft.**
Ostrom u. 27., 1st floor, No.1
1015 Budapest, Hungary
Утас: +420 235 522 252-3
Э-шуудан: hungary@dekonta.com

